**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

ХББОС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **СНАГ-2025/17/НА-СТА-ТЕЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2023 он | Монгол Улсын Ерөнхий аудиторын<br>орлогч: Я.Самбууням<br>Утас:261945 Цахим хаяг: sambuunyabya@audit.gov.mn<br>Санхүү, нийцлийн аудитын газрын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261663 Цахим хаяг: nararchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: В.Эрдэнэцогт<br>Утас: 260512 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Долгоржав<br>Утас: 261628 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2025.04.25 № 1590

танай ____________-ны № ____________-т

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН
САЙД Ж.БАТСУУРЬ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт 132,303.7 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Норм, стандарт, дүрэм боловсруулах зөвлөх үйлчилгээний 409.9 сая төгрөгийн гэрээний хэрэгжилт, захиалагчаас тавих хяналт хангалтгүй;
- Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан олон жил болсон, хэрэгжилтийн хугацаа дууссан, гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийт 951.8 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;
- Харилцагч байгууллагуудтай өглөгийн 17,326.6 сая төгрөг, авлагын 24,337.5 сая төгрөгийн үлдэгдлийн тооцоог нийлж, актаар баталгаажуулаагүй.
- Иргэнээс худалдаж авсан 670.9 сая төгрөгийн байрыг үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гараагүй гэсэн шалтгаанаар үндсэн хөрөнгөөр бүртгэлгүй, авлагаар бүртгэсэн;

- Норм, нормативын сангийн он дамжсан ажлыг бүрэн тусгаагүйгээс тайлант оны төлөвлөгөөг хэтрүүлэн өмнөх оны ажлын 345.9 сая төгрөгийн гүйцэтгэлийг олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.10, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.6, Засгийн газрын "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 2023 оны 456 дугаар тогтоолтой нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус яам "Орон сууцжуулалтын ойрын ирээдүйн бодлогыг хэлэлцэх олон улсын форум", НҮБ-ын Хүн амын нутагшилт, суурьшлын хөтөлбөр, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран "Хот байгуулалтын форум-2024"-ыг зохион байгуулахад нийт 267.7 сая төгрөг, Амины орон сууцны инноваци хөгжлийн төвтэй хамтран "Эрчим хүчний хэмнэлттэй, ногоон амины орон сууцны мэдээллийн төв"-ийг нээж ажиллуулахад 28.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Ерөнхий сайдын даалгаврын дагуу дулааны алдагдал багатай, ипотекийн зээлд хамрагдах боломжтой, тусгай хэрэгцээг хангасан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй, хөдөөгийн бодлогын хүрээнд орлогод нийцсэн, өртөг багатай орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээнд 34,000.0 сая төгрөгийг батлуулж, хэрэгжилтийг хангуулахаар 13,000.0 сая төгрөгийг "Төрийн орон сууцны корпораци" ТӨААТҮГ-т шилжүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны "Цемент шохой ТӨХХК-ий талаар авах арга хэмжээний тухай" 258 дугаар тогтоолоор тус ТӨХК-ийг "Эрдэнэс монгол" ХХК-ийн нэгдлийн бүрэлдэхүүнд ажилуулахаар тогтоосон байхад тус аж ахуйн нэгжийг Хот байгуулалт барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хамааруулж, санхүүгийн тайланг нэгтгэж байна.

**Бусад асуудлын хэсэг**

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар баталсан тус төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 2 хөтөлбөрийн хүрээнд 6 арга хэмжээний зорилтот түвшнийг тусгасан ба хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүн нь 97.4 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлд 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр орсон өөрчлөлтөөр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам байгуулагдаж, Засгийн газрын 2024 оны 51 дүгээр тогтоолоор яамны үйл ажиллагааны

стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, орон тоог баталсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Д.ЗАГДЖАВ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

*/мянган төгрөгөөр/*

| Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **1,037,893,527.0** | **1,647,158,313.6** |
| Мөнгөн хөрөнгө | 79,305,019.3 | 136,331,142.3 |
| Авлага | 69,134,095.5 | 77,717,282.3 |
| Урьдчилгаа | 25,956,523.0 | 5,245,682.7 |
| Бараа материал | 60,511,377.5 | 64,344,676.5 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 802,986,511.7 | 1,363,519,529.8 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **343,647,555.7** | **326,939,115.5** |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 1,000.0 | 3,111,309.1 |
| Үндсэн хөрөнгө | 343,646,555.7 | 323,827,806.4 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **1,381,541,082.7** | **1,974,097,429.2** |
| **Нийт өр төлбөр** | **738,252,433.5** | **816,895,695.7** |
| Богино хугацаат өр төлбөр | 188,123,311.9 | 258,099,274.5 |
| Урт хугацаат өр төлбөр | 550,129,121.7 | 558,796,421.2 |
| **Цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **643,288,649.2** | **1,157,201,733.4** |
| **Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,381,541,082.7** | **1,974,097,429.2** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

*/мянган төгрөгөөр/*

| Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **526,005,173.7** | **493,037,808.7** |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 219,500,165.2 | 105,930,682.2 |
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 306,505,008.5 | 387,107,126.5 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **168,759,200.2** | **78,172,080.8** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **168,759,200.2** | **78,172,080.8** |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 150,442,637.9 | 76,745,338.1 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 27,316,959.3 | 7,024,531.4 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 3,420,518.9 | 869,942.5 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,063,470.6 | 948,933.9 |
| Хангамж, бараа материалын зардал | 1,543,230.7 | 453,798.4 |
| Нормативт зардал | 11,393.2 | 3,996.1 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 459,594.0 | 327,947.4 |
| Томилолт, зочны зардал | 1,007,326.4 | 631,111.3 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 110,187,171.9 | 59,332,338.4 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 5,432,972.9 | 7,152,738.6 |
| ТАТААС | 4,966.2 | 0.0 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 18,311,596.2 | 1,426,742.7 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН** | **357,245,973.5** | **414,865,727.9** |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 118,523.9 | 6,659.0 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 5,064,022.6 | 27,887,336.9 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН** | **352,300,474.8** | **386,985,050.0** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө /өмч |
|---|---|---|---|
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **97,823,279.6** | **0.0** | **293,516,126.0** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.0 | 0.0 | 612,333.5 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **97,823,279.6** | **0.0** | **294,128,459.5** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.0 | 0.0 | 1,616.7 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 106,330.0 | 0.0 | 106,330.0 |
| Өмчид гарсан өөрчлөлт | 2,567,116.1 | 0.0 | 2,567,116.1 |
| Зарласан ногдол ашиг | 0.0 | 0.0 | (5,815,347.9) |
| Тайлант үеийн үр дүн | 0.0 | 0.0 | 352,300,474.8 |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **100,496,725.7** | **0.0** | **643,288,649.2** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (14,853,392.8) | 0.0 | (17,088,036.6) |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **85,643,332.9** | **0.0** | **626,200,612.6** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.0 | 0.0 | 6,076,750.5 |
| Өмчид гарсан өөрчлөлт | 87,968.8 | 0.0 | 138,319,057.0 |
| Зарласан ногдол ашиг | 0.0 | 0.0 | (379,736.7) |
| Тайлант үеийн үр дүн | 0.0 | 0.0 | 386,985,050.0 |
| **2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **85,731,301.7** | **0.0** | **1,157,201,733.4** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

*/мянган төгрөгөөр/*

| Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | 4,692,308,192.9 | 5,712,743,111.0 |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,625,141,863.1 | 1,641,852,232.5 |
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,067,166,329.8 | 4,070,890,878.6 |
| **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,513,472,598.6 | 1,666,324,283.4 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,513,472,598.6 | 1,666,324,283.4 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,332,755,076.7 | 1,623,029,666.1 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 563,802,989.7 | 376,857,602.3 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 120,200,789.9 | 89,068,192.0 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 107,263,997.5 | 118,987,836.0 |
| Хангамж, бараа материалын зардал | 491,251,846.4 | 280,857,127.0 |
| Нормативд зардал | 16,064.3 | 96,050.0 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 5,049,590.5 | 5,217,650.7 |
| Томилолт, зочны зардал | 7,419,091.4 | 6,174,645.5 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 986,225,782.5 | 458,344,262.1 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 51,524,924.5 | 287,426,300.7 |
| **ТАТААС** | 50,000.0 | 0.0 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 180,667,521.8 | 43,294,617.3 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 2,178,835,594.3 | 4,046,418,827.7 |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 16,569,089.7 | 24,833,368.3 |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 2,137,237,365.4 | 3,500,589,024.5 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 2,137,237,365.4 | 3,500,589,024.5 |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | (2,120,668,275.7) | (3,475,755,656.3) |
| **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | (11,612,251.4) | (401,940.9) |
| ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 50,000,000.0 | 0.0 |
| САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | 12,133,359.5 | 689,381.0 |
| **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 46,555,067.2 | 570,261,230.5 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 746,495,125.7 | 793,050,192.9 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 793,050,192.9 | 1,363,311,423.4 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **463,888,734,000.00** | **379,279,997,665.05** | **84,608,736,334.95** | **81.8** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **45,105,765,500.00** | **24,485,245,186.95** | **20,620,520,313.05** | **54.3** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **24,623,603,700.00** | **24,025,325,034.51** | **598,278,665.49** | **97.6** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **5,996,933,700.00** | **5,616,534,561.53** | **380,399,138.47** | **93.7** |
| 210101 | Үндсэн цалин | 4,283,731,000.00 | 3,849,449,458.84 | 434,281,541.16 | 89.9 |
| 210102 | Нэмэгдэл | 1,258,505,900.00 | 971,746,827.97 | 286,759,072.03 | 77.2 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 454,291,800.00 | 484,011,712.37 | (29,719,912.37) | 106.5 |
| 210104 | Урамшуулал | 405,000.00 | 306,488,562.35 | (306,083,562.35) | 75,676.2 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **758,246,900.00** | **706,449,530.39** | **51,797,369.61** | **93.2** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 515,844,200.00 | 477,725,028.75 | 38,119,171.25 | 92.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 60,600,800.00 | 57,064,734.12 | 3,536,065.88 | 94.2 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 30,301,400.00 | 32,543,463.39 | (2,242,063.39) | 107.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 30,300,900.00 | 29,481,375.00 | 819,525.00 | 97.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 121,199,600.00 | 109,634,929.13 | 11,564,670.87 | 90.5 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **368,403,600.00** | **297,252,798.00** | **71,150,802.00** | **80.7** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,008,800.00 | 1,608,322.00 | 5,400,478.00 | 22.9 |
| 210302 | Түлш, халаалт | 17,505,600.00 | 0.00 | 17,505,600.00 | 0.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 18,500,000.00 | 0.00 | 18,500,000.00 | 0.0 |
| 210304 | Байрны түрээс | 325,389,200.00 | 295,644,476.00 | 29,744,724.00 | 90.9 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **209,528,600.00** | **201,054,294.02** | **8,474,305.98** | **96.0** |
| 210401 | Бичиг хэрэг | 72,645,000.00 | 78,215,807.00 | (5,570,807.00) | 107.7 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 31,860,700.00 | 28,605,767.00 | 3,254,933.00 | 89.8 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 54,124,400.00 | 46,133,427.02 | 7,990,972.98 | 85.2 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 50,898,500.00 | 48,099,293.00 | 2,799,207.00 | 94.5 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **963,156,600.00** | **962,245,420.00** | **911,180.00** | **99.9** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 343,918,400.00 | 338,239,495.00 | 5,678,905.00 | 98.3 |
| 210602 | Тавилга | 100,038,200.00 | 99,467,882.00 | 570,318.00 | 99.4 |
| 210604 | Урсгал засвар | 519,200,000.00 | 524,538,043.00 | (5,338,043.00) | 101.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **259,098,500.00** | **236,819,126.20** | **22,279,373.80** | **91.4** |
| 210701 | Гадаад албан томилолт | 117,596,800.00 | 115,384,771.00 | 2,212,029.00 | 98.1 |
| 210702 | Дотоод албан томилолт | 124,101,700.00 | 104,209,094.20 | 19,892,605.80 | 84.0 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 17,400,000.00 | 17,225,261.00 | 174,739.00 | 99.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,014,365,800.00** | **1,963,022,322.62** | **51,343,477.38** | **97.5** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,952,882,100.00 | 1,907,595,068.42 | 45,287,031.58 | 97.7 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,000,000.00 | 0.00 | 5,000,000.00 | 0.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,353,500.00 | 2,094,928.80 | 258,571.20 | 89.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 604,200.00 | 247,952.00 | 356,248.00 | 41.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 64,000.00 | 35,000.00 | 29,000.00 | 54.7 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 14,766,000.00 | 14,527,633.40 | 238,366.60 | 98.4 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 38,696,000.00 | 38,521,740.00 | 174,260.00 | 99.5 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **14,053,870,000.00** | **14,041,946,981.75** | **11,923,018.25** | **99.9** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,034,250,000.00 | 14,022,345,981.75 | 11,904,018.25 | 99.9 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 19,620,000.00 | 19,601,000.00 | 19,000.00 | 99.9 |
| **212** | **ТАТААС** | **20,000,000,000.00** | **0.00** | **20,000,000,000.00** | **0.0** |
| **2122** | **Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас** | **20,000,000,000.00** | **0.00** | 20,000,000,000.00 | 0.0 |
| 212201 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 20,000,000,000.00 | 0.00 | 20,000,000,000.00 | 0.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **482,161,800.00** | **459,920,152.44** | **22,241,647.56** | **95.4** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **482,161,800.00** | **459,920,152.44** | **22,241,647.56** | **95.4** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 72,085,500.00 | 69,049,020.00 | 3,036,480.00 | 95.8 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 300,186,000.00 | 284,900,000.00 | 15,286,000.00 | 94.9 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 109,890,300.00 | 105,971,132.44 | 3,919,167.56 | 96.4 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **413,782,968,500.00** | **349,794,752,478.10** | **63,988,216,021.90** | **84.5** |
| 220001 | Барилга байгууламж | 395,405,546,900.00 | 334,035,380,583.10 | 61,370,166,316.90 | 84.5 |
| 221001 | Их засвар | 6,770,965,300.00 | 6,617,622,272.00 | 153,343,028.00 | 97.7 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 11,606,456,300.00 | 9,141,749,623.00 | 2,464,706,677.00 | 78.8 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **5,000,000,000.00** | **5,000,000,000.00** | **0.00** | **100.0** |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 5,000,000,000.00 | 5,000,000,000.00 | 0.00 | 100.0 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **463,888,734,000.00** | **379,279,997,665.05** | **84,608,736,334.95** | **81.8** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **463,888,734,000.00** | **379,279,997,665.05** | **84,608,736,334.95** | **81.8** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 463,888,734,000.00 | 379,279,997,665.05 | 84,608,736,334.95 | 81.8 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **299** | **301** | (2.00) | 100.7 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **3** | **3** | 0.00 | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 3 | 3 | 0.00 | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **148** | **149** | **(1.00)** | **100.7** |
| 620001 | Удирдах ажилтан | 13 | 19 | (6.00) | 146.2 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 135 | 130 | 5.00 | 96.3 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **148** | **149** | **(1.00)** | **100.7** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч | 88 | 78 | 10.00 | 88.6 |
| 650003 | Ажлын албаны албан хаагч | 4 | 4 | 0.00 | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч | 5 | 5 | 0.00 | 100.0 |
| 650011 | Улс төрийн албан хаагч | 2 | 2 | 0.00 | 100.0 |
| 650013 | УТҮГ | 49 | 60 | (11.00) | 122.4 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **7,202,990,719.92** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **7,202,990,719.92** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **7,116,305,786.01** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | **350,428,000.00** |
| 210304 | Байрны түрээс | | 350,428,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **108,605,000.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 41,500,300.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | 67,104,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **242,809,246.00** |
| 210701 | Гадаад албан томилолт | | 242,809,246.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **1,188,825,469.92** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 1,188,825,469.92 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **5,225,638,070.09** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 5,225,638,070.09 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **86,684,933.91** |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **86,684,933.91** |
| 213305 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 86,684,933.91 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **7,202,990,719.92** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **7,202,990,719.92** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 1,094,185,469.92 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 6,108,805,250.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 22,705,241.56 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **7,202,990,719.92** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **7,202,990,719.92** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **7,116,305,786.01** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | **350,428,000.00** |
| 210304 | Байрны түрээс | | 350,428,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **108,605,000.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 41,500,300.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | 67,104,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **242,809,246.00** |
| 210701 | Гадаад албан томилолт | | 242,809,246.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **1,188,825,469.92** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 1,188,825,469.92 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **5,225,638,070.09** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 5,225,638,070.09 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **86,684,933.91** |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **86,684,933.91** |
| 213305 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 86,684,933.91 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **7,202,990,719.92** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **7,202,990,719.92** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 1,094,185,469.92 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 6,108,805,250.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **22,705,241.56** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **0.00** |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 36,206.7 сая төгрөгийн алдаа илэрснээс 36,162.7 сая төгрөгийн алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 44.0 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн болон нийцлийн асуудлаар нийт 175,693.2 сая төгрөгийн 59 зөрчил илэрснээс 1,171.7 сая төгрөгийн зөрчилд 9 төлбөрийн акт тогтоож, 24,914.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 32 албан шаардлага хүргүүлж, 107,765.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 15 зөвлөмжийг өгч, 41,841.5 сая төгрөгийн зөрчилд 3 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүллээ.

Нийт залруулагдаагүй 132,303.7 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 127,053.7 сая төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

### 5.1 Харьяа байгууллагууд

ХББОС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 10 төсвийн захирагч нарын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” 1 (*Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ*), “Хязгаарлалттай” 4 (*Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам -ТШЗ, Төрийн орон сууцны корпораци ТӨХХК, Цемент шохой ХК ТӨҮГ, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороо ТӨҮГ*) дүгнэлт өгсөн байна.

### 5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар 88,178.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 951.8 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 87,226.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

#### 5.2.1 Төлбөрийн акт

1. Тус яамны хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд хуримтлагдсан 6-аас дээш жилийн насжилттай, гүйцэтгэгч нь гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн 15 аж ахуйн нэгж, байгууллагын нийт 208.2 сая төгрөгийн барьцаа хөрөнгийн үлдэгдэл, Засгийн газрын 2023 оны 456 дугаар тогтоолын хүрээнд Төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хэрэгжилтийн хугацаа дууссан төсөл, арга хэмжээнүүдийн 743.6 сая төгрөгийн санхүүжилтийн үлдэгдлийг төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 45 дугаар зүйлийн 45.2 "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2 "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжүүлээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Барьцаа дансанд хуримтлагдсан гүйцэтгэгч нь болон төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн хугацаа дууссан, гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн, 6-аас дээш жилийн насжилттай хөрөнгийн үлдэгдэл 951.8 сая төгрөгийг улсын төсвийн дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоох.

**5.2.2 Албан шаардлага**

ХББОСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дэргэдэх дотоод хяналт хангалтгүйгээс харьяа байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн болон нийцлийн асуудлаар нийт 175,694.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1,171.7 сая төгрөгийн зөрчилд 9 төлбөрийн акт тогтоож, 41,841.5 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 3 албан шаардлага, 24,914.7 сая төгрөгийн зөрчилд 32 албан шаардлага хүргүүлж, 107,766.3 сая төгрөгийн зөрчилд 11 зөвлөмж өгсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.10 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Харьяа байгууллагуудын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлэх, аудитаар илэрсэн алдаа, зөрчилд дүн шинжилгээ хийх, давтан гаргахгүй байх талаар нэгдсэн арга хэмжээ авч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

**5.2.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Авлага, өр төлбөрийн данстай холбоотой асуудал:**

<u>*Илрүүлэлт:*</u>

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын авлага 8,583.2 сая төгрөг буюу 12.4 хувиар, өр төлбөр өмнөх оноос 78,643.3 сая төгрөг буюу 10.7 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 14 дүгээр зүйлийн 14.2.3 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>*Өгсөн зөвлөмж*</u>:

Харьяа байгууллагуудын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлэх, авлага, өр төлбөрийг барагдуулах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

**2. Цалингийн зардалтай холбоотой асуудал**

<u>*Илрүүлэлт:*</u>

Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа, Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа нь улсын төсвөөс санхүүжигддэг бөгөөд Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 129 дүгээр тушаалаар "Албан хаагчдын үндсэн цалингийн хэмжээг тогтоосон нь Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор баталсан цалингийн сүлжээг үндэслээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний бүрэн эрх 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.10 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг

шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолын 2-т ”Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.” заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Засгийн газар, Сангийн сайдын баталсан цалингийн сүлжээний тогтоол, шийдвэрийг үндэслэн цалин хөлсийг зөв тогтоож, хэрэгжүүлэх, цаашид зөрчлийг давтахгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 36,206.7 сая төгрөгийн алдаа илэрснээс 36,162.7 сая төгрөгийн алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 44.0 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

*/сая төгрөгөөр/*

| д/д | Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | **Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын харьяа байгууллагууд** | | | | | | | | | | | | |
| 1 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам ТШЗ | 3 | 1,452.7 | | | 3 | 1,452.7 | 3 | 1,452.7 | | | | |
| 2 | Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ | 3 | 33,037.2 | | | 3 | 33,037.2 | 3 | 33,037.2 | | | | |
| 3 | Төрийн орон сууцны корпораци ТӨХХК | 5 | 47.1 | | | 5 | 47.1 | 5 | 47.1 | | | | |
| 4 | Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа ТШЗ | 4 | 548.3 | | | 3 | 504.3 | 3 | 504.3 | 1 | 44.0 | 1 | 44.0 |
| 5 | Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа ТШЗ | 2 | 1,066.0 | | | 2 | 1,066.0 | 2 | 1,066.0 | | | | |
| 6 | Цемент шохой ТӨХХК | 1 | 55.4 | | | 1 | 55.4 | 1 | 55.4 | | | | |
| | **НИЙТ ДҮН** | **18** | **36,206.7** | | | **17** | **36,162.7** | **17** | **36,162.7** | **1** | **44.0** | **1** | **44.0** |

### 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн асуудлаар нийт 132,303.7 сая төгрөгийн 51 зөрчил илэрснээс 1,171.7 сая төгрөгийн зөрчилд 9 төлбөрийн акт тогтоож, 2,810.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 29 албан шаардлага хүргүүлж, 87,457.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 11 зөвлөмжийг өгч, 40,864.9 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүллээ.

*/сая төгрөгөөр/*

| № | Шалгагдагч байгууллагын нэр | Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудал | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийт зөрчил | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцох албан тушаалтан | Хууль хяналтын байгууллагад |

| | | | | | | | | | | | шилүүлэх асуудал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| 1 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд | 3 | 87,226.4 | 0 | 0.0 | 1 | 0.0 | 2 | 87,226.4 | | |
| | **Дүн** | **3** | **87,226.4** | **0** | **0.0** | **1** | **0.0** | **2** | **87,226.4** | | |
| | **Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын харьяа байгууллагууд** | | | | | | | | | | |
| 1 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам | 9 | 596.2 | 2 | 190.0 | 3 | 341.7 | 4 | 64.4 | | |
| 2 | Хөрөнгө оруулалт, их засварын данс ТШЗ | 1 | 951.8 | 0 | 0.0 | 1 | 951.8 | 0 | 0.0 | | |
| 3 | Барилгын норм норматив боловсруулах сан ТӨҮГ | 7 | 409.8 | 1 | 10.0 | 6 | 399.8 | 0 | 0.0 | | |
| 4 | Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ | 2 | 14.0 | 1 | 5.5 | 1 | 8.4 | 0 | 0.0 | | |
| 5 | Төрийн орон сууцны корпораци ТӨХХК | 10 | 40,950.4 | 1 | 1.6 | 6 | 83.2 | 1 | 0.7 | 40,864.9 | |
| 6 | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороо ТӨҮГ | 5 | 1,120.6 | 2 | 9.9 | 3 | 1,110.7 | 0 | 0.0 | | |
| 7 | Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа ТШЗ | 5 | 87.2 | 1 | 2.8 | 4 | 84.4 | 0 | 0.0 | | |
| 8 | Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа ТШЗ | 4 | 166.7 | 0 | 0.0 | 1 | 0.0 | 3 | 165.7 | | |
| 9 | Цемент шохой ХК ТӨХХК | 5 | 781.7 | 0 | 0.0 | 4 | 781.7 | 1 | 0.0 | | |
| | **Дүн** | **48** | **45,077.3** | **9** | **1,171.7** | **28** | **2,810.0** | **9** | **230.7** | **40,864.9** | |
| | **НИЙТ ДҮН** | **51** | **132,303.7** | **9** | **1,171.7** | **29** | **2,810.0** | **11** | **87,457.2** | **40,864.9** | |

### 6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Аудитаар нийцлийн асуудлаар нийт 43,389.5 сая төгрөгийн 8 зөрчил илэрснээс 22,104.7 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 20,308.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлж, 976.6 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүллээ.

*/сая төгрөгөөр/*

| № | Шалгагдагч байгууллагын нэр | Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийт зөрчил | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцох | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | **Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын харьяа байгууллагууд** | | | | | | | | |
| 1 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам ТШЗ | 1 | 234.5 | 1 | 234.5 | | | | |
| 2 | Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ | 2 | 27.7 | | | 2 | 27.7 | | |
| 3 | Төрийн орон сууцны корпораци ТӨХХК | 1 | 976.6 | | | | | 1 | 976.6 |
| 4 | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороо ТӨҮГ | 1 | 894.7 | 1 | 894.7 | | | | |
| 5 | Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа ТШЗ | 1 | 280.6 | | | 1 | 280.6 | | |
| 6 | Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа ТШЗ | 1 | 20,000.0 | | | 1 | 20,000.0 | | |
| 7 | Цемент шохой ТӨХХК | 1 | 20,975.5 | 1 | 20,975.5 | | | | |
| | **Нийт дүн** | **8** | **43,389.5** | **3** | **22,104.7** | **4** | **20,308.2** | **1** | **976.6** |